



СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

Дотоод аудитын нэр: Аялал жуулчлалын салбарын төсөв,
санхүү, хөрөнгө оруулалтын үр дүн
Хамрагдсан байгууллага: Яамны холбогдох нэгж, Аялал жуулчлалын мэргэжлийн
холбоо НЭЗХЭ
Шалгалтын тайлангийн код: ХШҮДАГ-2024/ДА/18

Аудитын дүгнэлт:

БОАЖЯ /хуучин нэрээр/ нь Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийн 11 зорилт 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 13,199.8 сая төгрөгийн төлөвлөсөн бөгөөд ажлын гүйцэтгэл нь 2024 оны III улирлын байдлаар 9 зорилт 43 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 8,283.2 сая төгрөгийн 68 гэрээ байгуулж, 5,025.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Харин 21 арга хэмжээнд төсөвлөсөн 4,916.6 сая төгрөгийн төсөв зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна.

Тайлант хугацаанд гэрээ хийгдсэн 43 арга хэмжээнээс 7 ажлын гэрээ дүгнэгдэж 1,019.1 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон, 36 арга хэмжээний гэрээний урьдчилгаа 4,006.3 сая төгрөг олгож, гэрээний хугацаа дууссан байхад 3,257.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй, гэрээний хугацаа зөрчсөн байна.

Улсын төсөвт батлагдсан аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалтын 8 ажлын худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг 58.3 хувьтай гэж дүгнэв.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэгч, захиалагч БОАЖЯ /хуучин нэрээр/, гэрээний дагуу төсвийн зарцуулалтын эрх хүлээсэн АЖМХ болон гүйцэтгэгч байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд 398.0 сая төгрөгийн санхүүгийн алдаа дутагдал илэрсэн тул хөтөлбөрийн хэрэгжилтэд дотоод хяналтыг “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлт өгч байна.

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР1

1.ТАНИЛЦУУЛГА.....2

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ2

2.1. Аудитын зорилго:.....2

2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт2

2.3. Аудитын арга, аргачлал2

2.4. Өмнөх шалгалтын талаар3

3. ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТӨЛӨВШИЛ.....3

3.1. Засаглалын удирдлагын талаар3

3.2. Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын талаар4

4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР4

4.1 БОАЖЯ-ны сайдын шийдвэрээр яамны ТНБД-д зарцуулалтын эрхийг шилжүүлсэн хөтөлбөр арга хэмжээний үр дүн.....6

4.2 “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” НЭЗХЭ-нд зарцуулалтын эрхийг шилжүүлсэн хөтөлбөр арга хэмжээний үр дүн10

4.3 Салбарын хөрөнгө оруулалтын үр дүн:.....11

5. АУДИТЫН ҮР ДҮН.....Error! Bookmark not defined.

5.1. Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр.....Error! Bookmark not defined.

6.НЭГДСЭН ДҮГНЭЛТ.....12

7. САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....13

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АЖТХ	Аялал жуулчлалын тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
ССАЖЗЯ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ХШҮДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
АЖМХ	Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо
НЭЗХЭ	Нийтийн эрх зүйт хуулийн этгээд
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТХААГ	Төрийн худалдан авах ажиллагааны газар

1. ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дотоод аудитын дүрэм”-ын 5.1, 5.2, 7.2, 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн Соёлын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр баталсан удирдамжийн дагуу ХШҮДАГ-ын дарга Д.Түмэндэмбэрэл, шинжээч Ц.Алтанхуяг, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах мэргэжилтэн Б.Мандахмаа нар дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1. Аудитын зорилго:

Аялал жуулчлалын салбарын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлэх, төсөв санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний хэрэгжилтэд дотоод аудит хийж, бодит нөхцөл байдлыг ТЕЗ-д танилцуулах, цаашид үр нөлөөг нэмэгдүүлэх санал дүгнэлт гарган, зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Хамарсан хүрээ: Аялал жуулчлалын салбарын 2024 оны III улирлын байдлаарх санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд дотоод аудитыг яамны холбогдох газар, нэгж болон “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” зэрэг бусад гэрээгээр ажил гүйцэтгэсэн байгууллагуудыг хамруулан гүйцэтгэсэн.

Хязгаарлалт: Хамрах хүрээний хязгаарлалт байхгүй. Байгаль орчин, аялал жуулчлалын яам /хуучин нэрээр/-ны 2023 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас өгсөн аудитын тайланд аялал жуулчлалын салбарын төсөв, санхүүгийн зарцуулалттай холбоотой дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах гэхэд холбогдох мэдээ, тайланг БОАЖЯ /хуучин нэрээр/ хүлээлцээгүй тул хойшлов.

2.3. Аудитын арга, аргачлал

Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, Соёлын сайдын 2022 оны А/118 дугаар тушаалаар баталсан “Дотоод аудитыг гүйцэтгэх аргачлал”-ыг мөрдөж дотоод аудитыг гүйцэтгэсэн болно.

Аудитад дараах хууль эрх зүйн актуудыг шалгуур болгов. Үүнд:

- ✓ Аялал жуулчлалын тухай
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай;
- ✓ Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- ✓ Төрийн аудитын тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Шилэн дансны тухай хууль;
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль;
- ✓ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
- ✓ Нийгмийн даатгалын тухай хууль;
- ✓ Бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт.

2.4. Өмнөх шалгалтын талаар

Өмнө нь тус салбарын хэмжээнд дотоод аудитын хяналт шалгалт хийгдээгүй.

3. ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТӨЛӨВШИЛ

3.1. Засаглалын удирдлагын талаар

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлд тусгасан “Төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг бусад байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх” талаар зохицуулсан заалтын 1 дэх хэсэгт “Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно.”, 2 дахь хэсэгт “Төрийн гүйцэтгэх байгууллагын чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж, тэр тухайдаа улсын төсвөөс санхүүжиж байгаа байгууллага нь Засгийн газрын шийдвэрийг биелүүлж, уг ажлаа Монгол Улсын зохих сайдын өмнө хариуцна.” гэж заасны дагуу, мөн Төсвийн тухай хуулийн 6.4.3.иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой хөтөлбөр, арга хэмжээг тэдгээрээр гүйцэтгүүлэх чиглэл баримтлах заалтын хүрээнд Засгийн газрын “Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай” 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 370 дугаар тогтоол батлагдсан байна.

Энэ тогтоолын 1 дүгээр заалтад дараах чиг үүргийг Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо /цаашид АЖМХ гэх/ -гоор гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхийг БОАЖ-ын /хуучин нэрээр/ сайдад зөвшөөрсөн байна. Үүнд:

- Монгол Улсын аялал жуулчлалын чиглэлээр гадаадад сурталчлах;
- Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх;
- Аялал жуулчлалын үйлчилгээнд олон улсын холбогдох стандартыг нэвтрүүлэх;
- АЖБ-ын ангилал зэрэглэл тогтоох, хүний нөөцийн сургалт;
- Аялал жуулчлалын тухай хуулийн 10.5-д заасан жуулчны хөтөч-тайлбарлагчид үнэмлэх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, мэргэжлийн үр чадварын зэрэглэл тогтоох.

Дээрх тогтоолыг үндэслэн БОАЖ-ын сайд, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны ерөнхийлөгч нар “Төрийн зарим чиг үүргийг нийтийн эрх зүйн хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх тухай” гэрээг 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр байгуулж 8 зорилт, 35 арга хэмжээг гүйцэтгэх ажилд анх 6,378.7 сая төгрөгийг эрх шилжүүлэн зарцуулахаар тохирсон боловч уг тушаалд 2 удаа орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу 33 ажилд 6,844.9 сая төгрөгийн эрх олгосон байна.

Засгийн газрын тогтоолоор зөвшөөрөл өгсөн 5 чиглэлийн арга хэмжээг уг гэрээнд тусгасан байдлыг нягтлахад 1 дэх чиглэлээр -18, 2 дахь чиглэлээр 13, 3 дахь чиглэлээр -3, 4 дэх чиглэлээр -1 арга хэмжээ хийгдэхээр байна.

Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, жуулчны хөтөч-тайлбарлагч, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгчийн нэгдэл бүхий, ашгийн төлөө бус нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна.” гэж заасны дагуу 2023 оны 08 дугаар сарын 21-ны өдөр байгуулагдсан. Бүх гишүүдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор хуулийн этгээдийн дүрмийг баталсан. Удирдах зөвлөлийн даргаар Ц.Баатарсайхан ажилладаг.

Удирдах зөвлөлийн 2023 оны 07 дугаар тогтоолоор ажлын алба нь үндсэн 9 албан хаагч, гэрээт ажилтан гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Удирдах зөвлөлийн 2023 оны 05 дугаар тогтоолоор В.Нарангэрэлийг Ажлын албаны даргаар томилсон, даргын 2023 оны Б/08 дугаар тушаалаар Ц.Эрдэнэ -ийг гэрээт нягтлан бодогчоор томилж, Ажлын албаны 1, 2 дугаар гарын үсгийг зурж хөрөнгө, мөнгийг захиран зарцуулж байна.

Тус байгууллага нь 2023, 2024 оны хагас жилийн санхүү, татвар, нийгмийн даатгалын тайлангуудыг хуулийн хугацаанд нь холбогдох байгууллагуудад гарган өгч баталгаажуулсан байна.

3.2. Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын талаар

Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны дүрмийн 14.1.5-д заасны дагуу Хяналтын зөвлөл ажилладаг.

Тус хяналтын зөвлөл нь 2024 оны 3 дугаар сард байгууллагын 2023 оны санхүүгийн тайланд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, тайлан дүгнэлтээ Ажлын албанд хүргүүлсэн байна. Хяналтын зөвлөлийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн журналын орлогын дүн, ААНОАТ-ын тайлангийн дүнтэй зөрсөн, цахим баримтгүй гүйлгээг бүртгэсэн, авлага, өглөгийн гүйлгээг хаагаагүй, үндсэн хөрөнгийг бүртгээгүй, татвар, нийгмийн даатгалын өглөг үүсгэсэн зэрэг санхүүгийн зөрчил илэрсэн байна.

Цаашид анхаарвал зохих дараах асуудлаар зөвлөмж хүргүүлсэн. Үүнд:

- Төрийн бус байгууллагын тухай хуулийн дагуу санхүүгийн тайлангаа гаргах;
- Нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар бүртгэж, орлого, авлагыг зөв бүртгэх;
- Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэх;
- Гадаад гүйлгээ хийхдээ цалин хөлстэй холбоотой зардлаас хувь хүний орлогын албан татварын суутгал хийж тайлагнах;
- Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг хуулийн хугацаанд барагдуулах.

4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Хөтөлбөрийн батлагдсан төсөв, түүний өөрчлөлт

Аялал жуулчлалын хөтөлбөрийн зориулалтаар 2024 оны улсын төсөвт 12,799.8 сая төгрөгийн төсөв батлагдаж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд /хуучин нэрээр/ -ын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/174 дүгээр тушаалаар төсвийн хуваарийг 11 зорилтыг хэрэгжүүлэх 68 арга хэмжээнд хуваарилан баталсан байна. Энэ хөтөлбөрийн арга хэмжээний зарцуулалтын төсвийн хуваарьт ТНБД-ын тушаалаар 2 удаа өөрчлөлт оруулж, төсвийн дүнг 400.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 12,799.8 сая төгрөгийн санхүүжилт авч, 5,303.8 сая төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 7,496.0 сая төгрөгийг УИХ-ын ээлжит сонгуулийн дараа байгуулагдсан Засгийн газрын бүтцийн өөрчлөлтөөр ССАЖЗ-ын яаманд төсвийн тодотголоор шилжүүлсэн.

Хөтөлбөрийн зарцуулалтыг БОАЖЯ-ны ТНБД-ын эрх шилжүүлсэн тушаал, гүйцэтгэгч байгууллагатай хийсэн гэрээ, гэрээний биелэлтийн тайлан, гэрээ дүгнэсэн акт, санхүүгийн анхан шатны баримтад тулгуурлан хянаж дотоод аудитыг гүйцэтгэлээ.

Хөтөлбөрийн 11 зорилт 68 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын гүйцэтгэл нь 2024 оны III улирлын байдлаар 9 зорилт 43 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 5,025.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, мөнгөн дүнгээр тооцвол хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвийн гүйцэтгэл 38.07 хувьтай дүгнэгдэв.

Хүснэгт 1. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэл /сая төгрөгөөр/

№	ЗОРИЛТ	АХ-ний тоо	Төсөв	Хэрэгжүүлэгч		Гүйцэтгэл		Үлдэгдэл	Биелэлт хувь
				БОАЖЯ	АЖМХ	Арга хэмжэ	Мөнгөн дүн		
1	Аялал жуулчлалын бүсийн нөөц, даацыг тогтоох, олон улсад аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бодлого боловсруулах	3	90.0	2	1	3	63.0	27.0	70%
2	Монголын нүүдлийн соёлын онцлогт тохирсон үндэсний шинэлэг сор бүтээл, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж аялал жуулчлалыг дэмжих	19	1,060.0	6	13	11	680.7	379.3	64%
3	Хил орчмын аялал жуулчлалыг дэмжих, жуулчдын тоог нэмэгдүүлэх	2	20.0	2	0	1	-	20.0	0%
4	Аялал жуулчлалын сургалтын төв байгуулж, салбарын чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, бэлтгэх, мэргэжлийн удирдлагаар хангах	6	190.0	4	2	5	43.9	146.1	23%
5	Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр улсын болон олон улсын хэмжээнд аялал жуулчлалын байгууллага хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хамтран ажиллах	7	1,205.0	4	3	6	792.0	413.0	66%
6	Цахим Монгол арга хэмжээний хүрээнд аялал жуулчлалын салбарт технологийн дэвшил нэвтрүүлж, гадаад сурталчилгааг өргөжүүлэх	1	500.0		1			500.0	0%
7	Монгол Улсыг сурталчлах ажлыг холбогдох чиг үүргийн төрийн байгууллагатай хамтран зохион байгуулах	16	5,956.7	6	10	8	2,817.6	3,139.1	47%
8	Аялал жуулчлалын үйлчилгээний салбарт олон улсын стандартыг нэвтрүүлж байгаа аялал жуулчлалын байгууллагыг бодлогоор дэмжих	4	102.0	2	2	1	13.9	88.1	14%

9	Аялал жуулчлалын салбарын судалгаа, шинжилгээ, статистик мэдээллийн нэгдсэн сан цахим хэлбэрээр бүрдүүлэх	4	160.0	2	2	3	108.3	51.7	68%
10	Аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлэх	3	3,597.1	2	1	3	420.1	3,177.0	12%
11	Аялал жуулчлалын салбарт хамаарах асуудал шийдвэрлэх, зохицуулах	3	319.0	3	0	1	200.0	119.0	63%
		68	13,199.8	33	35	43	5,025.4	8,174.4	38%

4.1 БОАЖЯ-ны сайдын шийдвэрээр яамны ТНБД-д зарцуулалтын эрхийг шилжүүлсэн хөтөлбөр арга хэмжээний үр дүн.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 14.4 дэх хэсгийг үндэслэн БОАЖЯ-ны сайдын 2024 оны А/174 дүгээр тушаалаар яамны ТНБД-д аялал жуулчлалын хөтөлбөрийн 8 зорилт, 32 арга хэмжээг зохион байгуулж, гэрээ байгуулах ажилд 6,354.9 сая төгрөгийн төсвийн эрхийг шилжүүлсэн байна.

Эрх шилжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлийг шалгахад:

Аялал жуулчлалын хөтөлбөрийн батлагдсан хуваарьт БОАЖЯ-ны /хуучин нэрээр/ ТНБД-ын 2 удаагийн тушаалаар өөрчлөлт орсонтой холбоотойгоор Нүүдэлчин дэлхийн соёлын фестиваль наадмын төсөв хасагдсан байна.

Хөтөлбөрт батлагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх тухай БОАЖЯ-ны /хуучин нэрээр/ ТНБД-ын тушаал одоогоор гараагүй, гүйцэтгэгчтэй гэрээ хийгдээгүй 545.0 сая төгрөгийн 10 арга хэмжээ байна. Үүнд:

№	Арга хэмжээний нэр	Төсөв сая төгрөг
1	Олон улсын поло цом	100.0
2	Монгол, Орос, Хятад гурван улсын аялал жуулчлалын сайд нарын 8 дугаар хуралдаанд оролцох	10.0
3	Аялал жуулчлалын чиглэлээр суралцаж буй оюутнуудад Сайдын нэрэмжит тэтгэлэг зарлах	30.0
4	Дипломат харилцаа тогтоосон орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, хурал, аялал жуулчлалын арга хэмжээ зохион байгуулах, оролцох	30.0
5	Монголд зочлох жилийн сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хийх	70.0
6	Монголд зочлох жилийн сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хийх	70.0
7	Монголд зочлох жилийн сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хийх	70.0
8	Зүүн Азийн аялал жуулчлалын холбооны 18 дугаар чуулган	100.0
9	Эвент менежментийн олон улсын ISO 20121:2021 стандартыг Монголд нэвтрүүлэх	10.0
10	Үндэсний аудитын газраас тавьсан дүгнэлтийн дагуу төлөх өр, төлбөр	55.0
	Дүн	545.0

ТНБД-ын тушаал гарсан боловч хуваарилсан төсөв нь дуусаагүй буюу гэрээ бүрэн хийгдээгүй 3 арга хэмжээ байна. Үүнд: /сая төгрөгөөр/

№	Арга хэмжээний нэр	Огноо	Дугаар	Төсөв	Байгуулсан гэрээний дүн ХБГ	Зөрүү /гэрээ хийгдээгүй дүн/
1	Монгол орныг гадаадад сурталчлах "Go Mongolia" арга хэмжээний танилцуулга, материал бэлтгэх	5/15/2024	A/201	87.3	27.1	60
2	Монголд зочлох жилийн сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хийх	3/21/2024	A/105	70.0	48.0	22
3	Аялал жуулчлалыг хөгжүүлэх 55 тэрбумын хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаас	17/6/2024	A/282	3,041.1	581.9	2,459
				3,198.4	657.0	2,541.3

БОАЖЯ-ны /хуучин нэрээр/ ТНБД-ын тушаалын дагуу арга хэмжээ бүрэн хийгдсэн, санхүүгийн баримт нь БОАЖЯ-нд үлдсэн 3 арга хэмжээ байна. Үүнд: /сая төгрөгөөр/

№	Арга хэмжээний нэр	ТНБД-ын тушаалын огноо дугаар	Гэрээ байгуулсан гүйцэтгэгч байгууллага	Олгосон санхүүжилт
1	Ла Ла ланд сонгодог урлагийн наадам	24.03.06 №A/76	"Рейволюшн трэйд стар" ХХК	19.9
		24.03.07 №A/80	"Элит балет" ХХК	11.5
		24.03.07 №A/80	"UB босго" ХХК	18.7
2	"Улаанбаатар" олон улсын медиа урлагийн наадам	24.05.04 №A/185	Монголын урлагийн зөвлөл ТББ	20.0
3	Аялал жуулчлалын чиглэлээр Хөвсгөл аймагт сургалт хийх	24.04.26 №A/176	Монголын зочид буудлуудын холбоо ТББ	12.8
	Дүн			82.8

Ажил гүйцэтгэх гэрээний хугацаа дуусаагүй 3 арга хэмжээг хэрэгжүүлж буй 11 байгууллага 111.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, урьдчилгаа 77.7 сая төгрөгийн санхүүжилт авсан, санхүүжилтийн 30.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд:

- Аялал жуулчлалын хөгжлийн үзүүлэлтийг боловсруулж, орон нутгийн аялал жуулчлалын хөгжлийг шалгуур үзүүлэлтийн дагуу тодорхойлох ажлыг МУИС-ийн Бодлогын судалгааны лаборатори 40 сая төгрөгийн гэрээний дагуу хийж байна.
- Аялал жуулчлалын нөөц, даацад тулгуурлан улсын аялал жуулчлалын бүсийн шалгуур үзүүлэлт боловсруулж, аялал жуулчлалын бүс тогтоох ажлыг Хөгжлийн газарзүйн судалгааны хүрээлэн 20.0 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгэж байна.
- Монголд зочлох жилийн сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хийх ажлыг хэвлэл мэдээллийн 12 байгууллагатай гэрээ байгуулах шийдвэр гарсан, үүнээс Супервишн медиа групп, Ура медих ХХК, Вип эксперт ХХК-иудтай гэрээ хийсэн эсэх тодорхойгүй санхүүжилт олгоогүй, Монголын цахилгаан холбоо, Тайм фильм гэсэн 2 байгууллагад тус бүр 3.5 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилт олгосон, гэрээ байгуулсан баримт ирүүлээгүй байна.

БОАЖЯ-ны /хуучин нэрээр/ ТНБД-ын тушаалын дагуу гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, арга хэмжээг хэрэгжүүлж дууссан, санхүүжилтийн үлдэгдэлтэй, тооцоо нийлсэн акт үйлдэх шаардлагатай 7 арга хэмжээг хариуцагч 14 байгууллага байна. Үүнээс санхүүжилтийн 75.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй 8 байгууллага, гэрээний дүнгээс 1.3 сая төгрөгийн илүү санхүүжилт авсан 1 (Монгол төв ТББ) байгууллага, санхүүжилтээ бүрэн авсан 5 байгууллага байна. Үүнд:

Гэрээ байгуулсан гүйцэтгэгч байгууллага	Ажил гүйцэтгэх гэрээ		гэрээний дүн	Санхүүжилт олгосон дүн	Үлдэгдэл төлбөр
	огноо	дугаар			
"Сант тамир тайхар" ХХК	6/20/2024	24/286	20.0	14.0	6.0
Монголын зочид буудлуудын холбоо ТББ	6/6/2024	24/257	12.0	8.4	3.6
Монголын зочид буудлуудын холбоо ТББ	5/14/2024	24/168	25.0	17.5	7.5
Монголын зочид буудлуудын холбоо ТББ	6/14/2024	24/267	19.8	13.9	5.9
"Күүп аутсорсинг" ХХК	6/25/2024	24/297	10.0	7.0	3.0
Заан фүүдс ХХК	5/30/2024	24/183	6.1	3.6	2.4
Үндэсний газарзүй нийгэмлэг	4/8/2024	A/137	156.8	109.8	47.0
"Монтэктрейд" ХХК	14/5/2024	24/160	11.5	11.1	0.4
Монгол төв ТББ	5/14/2024	24/166	100.0	101.3	(1.3)
			386.7	312.1	74.6

Хөтөлбөрт тусгагдсан дараах нэр бүхий 12 арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор БОАЖЯ /хуучин нэрээр/ ТНБД-ын баталсан тушаалын дагуу 1,851.6 сая төгрөгийн гэрээг гүйцэтгэгчтэй байгуулж, урьдчилгаа 1,434.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон баримт байгаа хэдий ч БОАЖЯ /хуучин нэрээр/ -аас санхүүгийн баримтыг манай яаманд хүлээлцээгүй тул санхүүжилт авсан нэр бүхий 14 байгууллагын ажлын гүйцэтгэлд үнэлгээ хийж чадаагүй болно.

Тухайлбал:

Тухайлбал:			/сая төгрөгөөр/			
№	Хэрэгжүүлэх арга хэмжээ		Гэрээ байгуулсан гүйцэтгэгч	гэрээний дүн	Санхүүжилт олгосон дүн	Үлдэгдэл төлбөр
1	Бодибилдинг фитнесийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн		“Монголын Бодибилдинг Фитнесссийн Хөгжлийн холбоо”	150.0	105.0	45.0
2	Дотоодын аялал жуулчлал, өвлийн аялал жуулчлалыг дэмжих төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх /“Нэг жуулчин-Нэг хонь”, “Хөх баавгай” хөтөлбөр		БОАЖЯ	200.0	166.3	30.2
3	Хил орчмын аялал жуулчлалын журам, маршрутыг батлуулж, хэрэгжилтийг хангах		БОАЖЯ	6.6	-	6.6
4	Аялал жуулчлалын чиглэлээр сургалт хийх	Хэнтий	Зочид буудлын холбоо ТББ	9.3	6.5	2.8
		Сэлэнгэ	БОАЖЯ	0.9	-	0.9
		Завхан	Зочид буудлын холбоо ТББ	8.2	5.7	2.5
5	Олон улсын туршлага судлах, хүний нөөцийг чадавхжуулах фам тур зохион байгуулах		БОАЖЯ	18.0	-	18.0

6	Дэлхийн аялал жуулчлалын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх, гишүүнчлэлийн төлбөр төлөх		БОАЖЯ	130.7	131.5	(0.8)
7	Дэлхийн аялал жуулчлалын өдөр, Монголын аялал жуулчлалын салбар үүсгэн байгуулагдсаны 70 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх		БОАЖЯ	100.0	-	100.0
8	Монгол орныг гадаадад сурталчлах "Go Mongolia" арга хэмжээний танилцуулга, материал бэлтгэх		Олон улсын аялал жуулчлалын сургалт, судалгааны хүрээлэн	18.2	-	18.2
9	Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 24/01 тогтоолоор байгуулагдсан АЖХҮХ-ны Ажлын албаны үйл ажиллагааны зардал		Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны ажлын алба	150.0	72.6	77.4
10	Аялал жуулчлалын хөгжлийн төвийг татан буулгахтай холбоотой үйл ажиллагааны зардал		Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ	200.0	200.0	-
11	Олон улсын үзэсгэлэн ФЕСПО-ийн өр төлбөр		БОАЖЯ	63.7	-	63.7
12	Монгол орныг гадаадад сурталчлах "Go Mongolia" арга хэмжээг зорилтот орнуудад зохион байгуулах (Орос, Хятад, Солонгос, Япон, Герман, Америк, Франц, Турк, Сингапур, Швейцарь г.м)	Япон	МК2 КОРПРЕЙШН	265.9	227.7	38.3
			Кинотех компани	46.0	39.4	6.6
			Japan air travel marketing	14.5	12.5	2.0
			Хаврын баяр 2024 3Б хороо	23.0	19.8	3.2
			Монгол Улсаас Япон улсад суугаа Элчин сайдын яам	4.1	9.5	(5.3)
			Босс технологи ХХК	25.6	23.0	2.6
			Грейтив арт ХХК	17.0	15.3	1.7
		Франц	Монгол Улсаас Франц улсад суугаа ЭСЯ	400.0	400.1	(0.1)
Дүн				1,851.6	1,438.3	413.3

Дээрх арга хэмжээг хариуцан ажилласан байгууллагуудаас гэрээний хэрэгжилтийн тайлан, санхүүгийн баримтыг хүлээн авч тооцоо нийлсэн актыг үйлдэн санхүүжилтийн 413.3 сая төгрөгийн үлдэгдлийг олгоход дотоод хяналтыг хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэв.

4.2 “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” НЭЗХЭ-нд зарцуулалтын эрхийг шилжүүлсэн хөтөлбөр арга хэмжээний үр дүн

Аялал жуулчлалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.4, 21.1.5 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 370 дугаар тогтоолыг үндэслэн БОАЖ-ын сайд, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны ерөнхийлөгч нар “Төрийн зарим чиг үүргийг нийтийн эрх зүйн хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх тухай” гэрээг 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр байгуулж 8 зорилт, 36 арга хэмжээг гүйцэтгэх ажилд 6,378.7 сая төгрөгийг эрх шилжүүлэн зарцуулахаар тохирсон боловч гүйцэтгэлээр 6,844.9 сая төгрөгийн гэрээ хийгдсэн байна.

- Энэхүү гэрээний хэрэгжилтийг шалгахад:
- Аялал жуулчлалын хөтөлбөрийн батлагдсан хуваарьт БОАЖЯ-ны /хуучин нэрээр/ ТНБД-ын 2 удаагийн тушаалаар өөрчлөлт орсонтой холбоотойгоор 3 арга хэмжээний төсөв хасагдсан байна. Үүнд:
- Цайны зам өв соёлын наадам
 - Монгол туургатны Харвуул их наадам
 - Аялал жуулчлалын хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа хийх, эрэлттэй мэргэжлийн жагсаалт гаргах

Хөтөлбөрт батлагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх тухай БОАЖЯ-ны /хуучин нэрээр/ ТНБД-ын тушаал одоогоор гараагүй, гүйцэтгэгчтэй гэрээ хийгдээгүй 1,087.0 сая төгрөгийн 11 арга хэмжээ байна. Үүнд:

№	Арга хэмжээний нэр	Төсөв сая төгрөг
1	Торгоны зам-Хархорин арга хэмжээ	10.0
2	Зэс фестиваль	20.0
3	“Бүх дэлхийн Алтаргана-2024” олон улсын 15 дугаар их наадам	50.0
4	Аялал жуулчлалын салбарын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах	15.0
5	Монгол Улсыг гадаад, дотоодод сурталчлах контентуудын тоо нэмэгдүүлэх	500.0
6	Монголд зочлох жилийн сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хийх	70.0
7	Жуулчдад зориулсан “Наадам найт” арга хэмжээг Үндэсний их баяр наадмын хүрээнд зохион байгуулах	200.0
8	Цайны зам авто ралли /Хятад-Монгол-Орос/	100.0
9	Олон улсын гольфийн тэмцээн	50.0
10	Зочлох үйлчилгээний стандартуудыг таниулах, мөрдүүлэх зорилгоор сургалт зохион байгуулах	62.0
11	Судалгаанд үндэслэн үндэсний хэмжээнд зэрэглэлтэй зочид буудлуудын аттестатчиллыг хийх	10.0
	Дүн	1,087.0

Хөтөлбөрт батлагдсан 22 арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор БОАЖЯ-ны /хуучин нэрээр/ ТНБД-ын 29 тушаалаар 5,472.9 сая төгрөгийн санхүүжилтийг АЖМХ-нд олгох шийдвэр гарсан байна.

Энэ шийдвэрийн дагуу БОАЖЯ болон АЖМХ хооронд мөн дүнгээр 29 удаагийн гэрээ байгуулагдан 3,051.2 сая төгрөгийн санхүүжилт олгож 2,421.7 сая төгрөгийн үлдэгдлийг дотоод аудитаар тулган баталгаажууллаа. Мазаалай наадмын хураамжийн 114.1 сая төгрөгийн гадаад гүйлгээг яамнаас шууд санхүүжилт олгосон байна.

4.3 Салбарын хөрөнгө оруулалтын үр дүн:

БОАЖ-ын /хуучин нэрээр/ сайдын 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтын багцад аялал жуулчлалын салбарын шилжих хөрөнгө оруулалт -1, шинээр эхлэх -8 арга хэмжээ батлагдаж, тухайн онд 16,399.6 сая төгрөг улсын төсөвт суусан байна.

Засгийн газрын 2023 оны 409 дүгээр тогтоолын дагуу БОАЖ-ын сайдын багцаас 3 арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Төрийн худалдан авах ажиллагааны газар /цаашид ТХААГ/ -т, 4 арга хэмжээний эрхийг Архангай, Увс аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна. Харин улсын хэмжээнд “Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг байгуулах арга хэмжээг БОАЖЯ зохион байгуулахаар төлөвлөгөөг баталсан байна.

Энэ оны ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдсан 8 төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан үр дүнг нэгтгэн авч үзвэл:

- ТХААГ нь эрх шилжүүлж авсан 3 төсөл, арга хэмжээний тендерийн сонгон шалгаруулалтыг тус бүр 3 удаа зарлаж гүйцэтгэгчдийг шалгаруулж гэрээг байгуулсан байна. Үүнд:
 - ✚ Завхан аймгийн Улиастай сумын Жавхлант цогцолборын барилгын гүйцэтгэгчээр Этүгэн жим ХХК шалгарч, 3,176.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан.
 - ✚ Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Соёмбо цогцолборын явган хүний зам, дугуйн замын барилгын ажил гүйцэтгэгчээр Нанодизель ХХК шалгарч, 2,921.8 сая төгрөгийн гэрээ байгуулсан.
 - ✚ Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хүслийн хад цогцолборын барилгын ажил гүйцэтгэгчээр Жавхланхүслэн ХХК шалгарч, 1,570.2 сая төгрөгийн гэрээ байгуулсан.
- Архангай аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн “Архангай аймгийн Цахир сумын аялал жуулчлал, соёлын өвийн барилга”-ын тендерийг 3 удаа зарлаж тендерт оролцогч байхгүй шалтгаанаар амжилтгүй болсон.
- Увс аймгийн Засаг дарга эрх шилжүүлж авсан 2 арга хэмжээний тендерийг нэг удаа зарлаж тендерт оролцогч байхгүй шалтгаанаар амжилтгүй болсон, 1 төсөл арга хэмжээний тендерийг зарлаагүй байна. Үүнд: Хяргас сумын Хяргас нуурын эрэгт барих отоглох цэг, Тариалан сумын Увс нуурын эрэгт барих отоглох цэг, Улсын чанартай зам дагуу Үйлчилгээний цогцолбор барилга.
- БОАЖЯ нь Улсын хэмжээнд ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг барих барилгын ажилд батлагдсан 2,325.0 сая төгрөгийн төсөвтэй ажлын сонгон шалгаруулалтыг 6 цэгт байгуулах тендерийг багцлан зарласан байна.
 - ✚ Булган аймгийн Рашаант суманд барих отоглох цэгийн барилгын ажлын гүйцэтгэгчээр Дүүрэн цацрах ХХК шалгарч, 409.2 сая төгрөгийн гэрээ байгуулсан.
 - ✚ Завхан аймгийн Тэлмэн суманд барих отоглох цэгийн барилгын ажлын гүйцэтгэгчээр Өндөр говь мэргэн констракшн ХХК шалгарч, 367.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан.
 - ✚ Хэнтий аймгийн Өмнөдэлгэр суманд барих отоглох цэгийн барилгын ажлын гүйцэтгэгчээр Нутгийн баруун мод ХХК шалгарч, 373.2 сая төгрөгийн гэрээ байгуулсан.
 - ✚ Говь-Алтай аймгийн Хөхморьт суманд барих отоглох цэгийн барилгын ажлын гүйцэтгэгчээр Хос гандирс ХХК шалгарч, 376.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан.
 - ✚ Өвөрхангай аймгийн Хужирт суманд барих отоглох цэгийн тендер зарлахад Булган аймгийн Рашаант суманд барих отоглох цэгийн барилгын

гүйцэтгэгчээр шалгарсан оролцогч тендер ирүүлж, ажиллах хүчний нөөц давхардсан шалтгаанаар хасагдаж, тендер амжилтгүй болсон.



Булган аймгийн Баян-Агт суманд барих отоглох цэгийн тендер зарлахад оролцогч байхгүй шалтгаанаар амжилтгүй болсон.

Салбарын хэмжээнд 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн дүгнэхэд ТХААГ -100 хувь, Архангай аймгийн Засаг дарга -30 хувьтай, Увс аймгийн Засаг дарга 20 хувьтай, БОАЖЯ – 76.7 хувьтай, нэгдсэн дүн 58.3 хувийн биелэлттэй байна.

Аялал жуулчлалын салбарын 2021-2024 оны хөрөнгө оруулалтын судалгаа

Үзүүлэлт		Барилга байгууламж	Урсгал засвар	ТЭЗҮ	Нийт
2021 он	Төслийн тоо	10	1		11
	Батлагдсан төсөв	10,197.0	650.0		10,847.0
2022 он	Төслийн тоо	10	1	2	13
	Батлагдсан төсөв	9,422.6	350.0	800.0	10,572.6
2023 он	Төслийн тоо	10	1	2	13
	Батлагдсан төсөв	10,579.4	2,515.3	610.3	13,705.0
2024 он	Төслийн тоо	9			9
	Батлагдсан төсөв	16,399.6			16,399.6

Сүүлийн 4 жилд тус салбарт аялал жуулчлалын чиглэлийн 27 барилга, байгууламж барих ажилд 46,596.6 сая төгрөг, их засварын 1 ажилд 3,513.3 сая төгрөг, ТЭЗҮ боловсруулах 2 ажилд 818.3 сая төгрөг улсын төсвөөс батлагдсан байна.

Эдгээр ажлуудын анхны төсөвт өртгийг сүүлд батлагдсан төсөвт өртөгтэй харьцуулан шинжлэхэд 7 барилгын өртөг 5,422.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Мөн ашиглалтад ороогүй, барилга угсралтын ажил царцсан ажлуудыг салбарын хөрөнгө оруулалтын аудитаар дахин хянаж шалгахаар шийдвэрлэв.

5.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Аялал жуулчлалын салбарын төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын үр дүнд гүйцэтгэсэн дотоод аудитын дүн:

Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийн 11 зорилт 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 13,199.8 сая төгрөгийн төлөвлөсөн бөгөөд ажлын гүйцэтгэл нь 2024 оны III улирлын байдлаар 9 зорилт 43 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 8,283.2 сая төгрөгийн 68 гэрээ байгуулж, 5,025.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Харин 21 арга хэмжээнд төсөвлөсөн 4,916.6 сая төгрөгийн төсөв зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна.

Тайлант хугацаанд гэрээ хийгдсэн 43 арга хэмжээнээс 7 ажлын гэрээ дүгнэгдэж 1,019.1 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон, 36 арга хэмжээний гэрээний урьдчилгаа 4,006.3 сая төгрөг олгож, гэрээний хугацаа дууссан байхад 3,257.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй, гэрээний хугацаа зөрчсөн байна.

Улсын төсөвт батлагдсан аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалтын 8 ажлын худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг 58.3 хувьтай гэж дүгнэв.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэгч, захиалагч БОАЖЯ /хуучин нэрээр/, гэрээний дагуу төсвийн зарцуулалтын эрх хүлээсэн АЖМХ болон гүйцэтгэгч байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд 398.0 сая төгрөгийн санхүүгийн алдаа дутагдал илэрсэн тул хөтөлбөрийн хэрэгжилтэд дотоод хяналтыг “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлт өгч байна.

Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдлийг харилцагч байгууллагатай хийсэн тооцоо нийлсэн актгүй, үндэслэлгүй нэхэмжлэл гаргасан 4 ажлын санхүүжилтийн үлдэгдлийг 398.0 сая төгрөгөөр бууруулан олгохоор дүгнэлт гаргасан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдсан 6 барилга байгууламжийн сонгон шалгаруулалтыг шуурхай зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулах үүргийг Архангай, Увс аймгийн Засаг дарга, яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн даргад хариуцуулах шаардлагатай байна.

Аудитаар илэрсэн тайланд дурдсан алдаа дутагдалыг залруулах, аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж биелэлтийг цаглаварт хугацааны дотор ХШҮДАГ-т албан бичгээр хавсарган ирүүлэхийг холбогдох газар, байгууллагад мэдэгдье.

7. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- 7.1 Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээнд АЖТХ-ийн 5.3.3-т заасны дагуу “спортын арга хэмжээ, үзмэр болон урлаг, соёлын бусад үйлчилгээ” хамаардаг тул 2024 онд 22 соёлын хөтөлбөр арга хэмжээ, эвент, наадмууд санхүүжүүлсэн нь соёлын салбарын ажил үйлчилгээтэй давхцаж байгаа учраас цаашид хөтөлбөр арга хэмжээний зардлын хуваарилалтын давхцалыг арилгах, аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого боловсруулж хөтөлбөрийг санхүүжүүлэх, соёл, урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс ялгаатай төлөвлөх.
- 7.2 АЖТХ-ийн “26.2.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцогчдыг **сургалт, зөвлөгөө, мэдээлэл, мэргэжлийн арга зүйгээр хангах, аялал жуулчлалын байгууллагын ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлах болон энэ хуульд заасан чиг үүргийг** хэрэгжүүлнэ” гэсэн чиг үүрэгтэй тул А/449 тушаалын 25, 30, 36, 55, 56, 57-т заасан хүний нөөцийг чадавхжуулах сургалт зохион байгуулах, фам түр зохион байгуулах арга хэмжээнүүдийг яамны чиг үүргээс Аялал жуулчлалын холбоонд хариуцуулж байх.
- 7.3 ЗГ-ын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Төрийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгах тухай” 36-р тогтоолоор Аялал жуулчлалын хөгжлийн төвийг татан буулгаж, хөтөлбөр арга хэмжээний төсвөөс 200.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон, мөн тус газартай холбоотой ҮАГ-аас тавьсан 55.0 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулах төсвийг баталсан боловч төлөөгүй байна. Иймд тус байгууллагатай холбоотой дээрх зардлын гүйцэтгэлийг нарийвчлан шалгах.
- 7.4 АЖТХ-ийн 20 дугаар зүйлд заасны дагуу Засгийн газрын 2023 оны 384 дүгээр тогтоолоор Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хороо байгуулагдсан. Тус тогтоолын 5.1-т “Үндэсний хороо нь ажлын албатай байх бөгөөд өдөр тутмын үйл ажиллагааг ажлын алба хариуцан гүйцэтгэнэ. Ажлын алба нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй байна.” гэж заасны дагуу Үндэсний хорооны 2024 оны 2-р сарын 28-ны өдрийн 24/01 тогтоолоор Ажлын албыг байгуулсан. Ажлын албаны үйл ажиллагааны зардалд БОАЖ-ын сайдын 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/449 дүгээр тушаалын 65 дугаар хэсэгт 150 сая төгрөг төсөвлөснөөс 72.6 сая төгрөгийн зардал гарсныг нарийвчлан шалгах.

Яамны Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт

Хугацаа

- Зөвлөмж 1. Хууль болон Засгийн газраас зөвшөөрөл олгосон чиглэлийн хүрээнд хөтөлбөрт туссан арга хэмжээг АЖМХ-гоор гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байх;
- Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Н.Болормаа, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ТЭЗ-ийн ерөнхий нягтлан бодогч Б.Мандахмаа нарт**
- Зөвлөмж 2. Аялал жуулчлалын хөтөлбөрийн зарцуулалтын төсвийг зардлын ангиллаар дэлгэрэнгүй боловсруулж батлуулах, гүйцэтгэлийн тайланд төсөвлөсөн зардлын зөрүүгийн шалтгаан нөхцөлд тайлбар гаргаж, батлагдсан төсвийг хэтрүүлэхгүй ажиллах.
- Зөвлөмж 3. АЖМХ-ны хариуцан хэрэгжүүлж буй арга хэмжээний биелэлтэд захиалагчийн хяналтыг үр нөлөөтэй тавьж дотоод хяналтыг сайжруулан, санхүүгийн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж гэрээнд заасан санхүүжилтийг тооцоо нийлсэн актаар олгох шаардлагыг хангаж ажиллах.
- Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны ажлын албаны дарга В.Нарангэрэлд**
- Зөвлөмж 4. АЖМХ-ны хариуцаж хэрэгжүүлж буй арга хэмжээний төсвийн зардлын ангиллаар дэлгэрэнгүй боловсруулж батлуулах, гүйцэтгэлийн тайланд төсөвлөсөн зардлын зөрүүгийн шалтгаан нөхцөлд тайлбар гаргаж, батлагдсан төсвийг хэтрүүлэхгүй ажиллах.
- Зөвлөмж 5. АЖМХ-ны хариуцан хэрэгжүүлж буй арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний биелэлтэд тавих дотоод хяналтыг сайжруулан, санхүүгийн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж гэрээнд заасан санхүүжилтийг тооцоо нийлсэн актаар олгож байх.
- 2025 оны 03-р сарын 25-ны дотор
- 2025 оны 03-р сарын 25-ны дотор
- 2025 оны 03-р сарын 25-ны дотор

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

---оОо---